



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/85/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 130

танай _____ ны № _____ Т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЕБС-ЫН
ЗАХИРАЛ Г.ЭНХТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 131 дүгээр тогтоолоор боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хөтөлбөр хийгдэж эхэлсэн бөгөөд гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн системд шилжин үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийг Улсын төсвөөс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд Улсын төсвөөс 1,446,748.0, орон нутгийн төсвөөс 349,233.5, дээд шатны төсвийн захирагчаас 10,290.0, бусад орлого 5,960.0 нийт 1,812,232.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Мөн IX дүгээр хуралдааны 03-р тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан ажлын шаардлага хангахгүй 158 нэр төрлийн 93,934.9 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг акталан ажилласан байна.

006020187

Ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой 144 нэр төрлийн 217,996.3 мянган төгрөгний хөрөнгийг дахин үнэлж хянуулан аймгийн орон нутгийн өмчийн газрын 2023 оны 41-р албан бичгийн дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн.

БШУЯ-аас ирүүлсэн дунд ангийн 3,524.4 мянган төгрөгний сурах бичгийг бараа материалын тусгай зориулалтын материал дансанд орлогод бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,548,665.00	87,317,057.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	29,473,045.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	29,473,045.18
3122	Гадаад валют	-	29,473,045.18
31221	Төрийн сангийн харилцах	-	29,473,045.18
33	АВЛАГА	32,888,850.00	714,250.00
335	Бусад авлага	32,888,850.00	714,250.00
3351	Байгууллагаас авах авлага	714,250.00	714,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,659,815.00	51,317,022.00
351	Түүхий эд материал	1,148,900.00	4,322,097.00
35110	Тусгай зориулалттай материал	-	3,524,397.00
35130	Эм боох материал	1,148,900.00	797,700.00
354	Хангамжийн материал	20,110,915.00	26,994,925.00
35410	Бичиг хэргийн материал	155,600.00	426,300.00
35420	Аж ахуйн материал	19,955,315.00	23,442,355.00
35460	Хүнсний материал	-	3,126,270.00
35600	Мал амьтад	20,400,000.00	20,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	5,812,740.00
36600	Бусад нөөц	-	5,812,740.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,597,094,124.61	1,639,650,403.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,597,094,124.61	1,639,650,403.93
392	Биет хөрөнгө	1,518,512,624.58	1,561,421,403.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,417,385,038.10	4,417,385,038.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,116,578,718.79)	(3,218,297,339.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,300,000.00	15,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,300,000.00)	(15,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	286,105,366.85	224,724,492.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(237,400,910.36)	(49,855,181.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	216,444,197.28	158,111,540.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	(153,195,378.64)	(70,100,835.99)
39209	Зам, гүүрийн байгууламж	26,282,800.00	26,282,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(12,292,041.21)	(13,591,181.10)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	59,000,000.00	59,000,000.00
39217	Ном	32,762,271.35	27,762,071.25
393	Биет бус хөрөнгө	78,581,500.03	78,229,000.00
39301	Програм хангамж	1,550,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(522,499.97)	(675,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	77,554,000.00	77,554,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,671,642,789.61	1,726,967,461.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,214,329.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,214,329.00
413	Өглөг	-	2,214,329.00
4136	Бусад өглөг	-	2,214,329.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,214,329.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,672,744,940.39	1,725,855,282.89
51	Засгийн газрын хувь оролцоо	1,672,744,940.39	1,725,855,282.89

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	617,318,336.99	617,318,336.99
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	617,318,336.99	617,318,336.99
512	Хуримтлагдсан үр дүн	(617,318,336.99)	(564,207,994.49)
51210	Өмнөх үеийн үр дүн	(617,318,336.99)	(617,318,336.99)
51220	Тайлант үеийн үр дүн	-	53,110,342.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,672,744,940.39	1,672,744,940.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,672,744,940.39	1,728,069,611.89

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,581,729,756.48	1,940,080,656.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,201,460.48	129,258,356.30
120	Нийтлэг татварын бус орлого	15,201,460.48	129,258,356.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,201,460.48	129,258,356.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,110,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	300,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,201,460.48	127,848,356.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,566,528,296.00	1,810,822,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,247,378,200.00	1,446,748,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,446,748,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,627,273.00	14,840,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	900,000.00	4,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,727,273.00	10,290,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	274,522,823.00	349,233,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	274,522,823.00	349,233,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,785,038,815.51	1,883,507,842.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,785,038,815.51	1,883,507,842.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,707,587,946.51	1,825,784,684.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	981,975,414.00	1,140,411,579.00
210101	Үндсэн цалин	582,894,449.00	786,458,736.00
210102	Нэмэгдэл	307,688,092.00	296,308,191.00
210104	Урамшуулал	91,392,873.00	57,644,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,102,769.00	141,741,294.79
210201	Тэтгэврийн даатгал	85,958,849.00	96,974,025.23
210202	Тэтгэмжийн даатгал	9,575,928.00	11,408,838.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,717,712.00	9,126,200.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,893,014.00	2,195,235.02
210205	Эрүүл мэндийн даатгал	18,957,266.00	22,036,996.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	290,266,848.54	278,052,729.00

210301	Гэрэл, цахилгаан	7,520,136.00	11,656,257.00
210302	Түлш, халаалт	280,090,513.54	263,151,888.00
210303	Цэвэр, бохир ус	2,656,199.00	3,244,584.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,406,764.42	400,708.00
210401	Бичиг хэрэг	1,316,743.00	5,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,465,230.00	395,108.00
2105	Нормативт зардал	47,149,106.63	57,056,740.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	375,323.47	961,600.00
210502	Хоол, хүнс	28,374,368.00	56,095,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,751,916.72	1,500,000.00
210604	Урсгал засвар	15,380,666.72	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,562,700.00	11,706,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,562,700.00	3,295,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,411,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,958,427.20	194,915,333.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,484,022.60	33,876,188.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,496,397.15	22,186,037.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,978,007.45	138,853,108.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,450,869.00	57,723,158.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,629,600.00	57,722,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,029,600.00	56,762,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	960,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	258.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	258.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(203,309,059.03)</u>	<u>56,572,813.59</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,680,000.00	6,400,000.00
145003	Хөрөнгө оруулалтын олз	6,680,000.00	6,400,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,100,000.00	9,862,471.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,012,471.09
225003	Хөрөнгө оруулалтын гарз	4,040,000.00	3,890,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,060,000.00	960,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,420,000.00)	(3,462,471.09)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(207,729,059.03)</u>	<u>53,110,342.50</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,569,417,598.00</u>	<u>1,812,232,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,889,302.00	1,410,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,889,302.00	1,410,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,889,302.00	1,410,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,889,302.00	1,110,000.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,566,528,296.00	1,810,822,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,247,378,200.00	1,446,748,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,446,748,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,627,273.00	14,840,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	900,000.00	4,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,727,273.00	10,290,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	274,522,823.00	349,233,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	274,522,823.00	349,233,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,540,964,298.00</u>	<u>1,744,444,454.82</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,540,964,298.00	1,744,444,454.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,466,034,089.00	1,677,819,176.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	981,975,414.00	1,140,411,579.00
210101	Үндсэн цалин	582,894,449.00	786,458,736.00
210102	Нэмэгдэл	307,688,092.00	296,308,191.00
210104	Урамшуулал	91,392,873.00	57,644,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,102,769.00	141,741,294.79
210201	Тэтгэврийн даатгал	85,958,849.00	96,974,025.23
210202	Тэтгэмжийн даатгал	9,575,928.00	11,408,838.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,717,712.00	9,126,200.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,893,014.00	2,195,235.02
210205	Эрүүл мэндийн даатгал	18,957,266.00	22,036,996.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,523,723.00	275,838,400.00
210301	Гэрэл, цахилгаан	7,112,616.00	11,656,257.00
210302	Түлш, халаалт	263,039,888.00	260,937,559.00
210303	Цэвэр, бохир ус	2,371,219.00	3,244,584.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,059,833.00	395,108.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,553,630.00	395,108.00
2105	Нормативт зардал	31,484,880.00	55,044,610.00
210502	Хоол, хүнс	28,236,280.00	55,044,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,999,100.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,999,100.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,659,900.00	11,706,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,659,900.00	3,295,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,411,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,814,470.00	51,181,885.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,275,548.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,814,470.00	22,906,337.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,930,209.00	66,625,278.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,108,940.00	66,625,020.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,308,940.00	66,625,020.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	258.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	258.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>28,453,300.00</u>	<u>67,787,845.18</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,453,300.00	38,314,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,453,300.00	38,314,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,453,300.00	38,314,800.00
222001	Тоног төхөөрөмж	16,279,800.00	38,314,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(28,453,300.00)</u>	<u>(38,314,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	29,473,045.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,473,045.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(411,690,527.96)	1,877,270,598.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(411,690,527.96)	1,877,270,598.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(205,627,809.03)	(205,627,809.03)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(617,318,336.99)	1,671,642,789.61

D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(617,318,336.99)	1,671,642,789.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(617,318,336.99)	1,671,642,789.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	53,110,342.50	53,110,342.50
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(564,207,994.49)	1,724,753,132.11

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	10290000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	10290000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	10290000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10290000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	10290000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	10290000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10290000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10290000
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа: Тус сургууль нь 2022 онд 587 хүүхэдтэй үйл ажиллгааг явуулж нийт 22 бүлэгтэй өдрийн 1 ээлжээр хичээллэн үйл ажиллагааг явуулсан

болно. Нийт 71 ажилчин албан хаагчтай. Үүнд удирдах -3, гүйцэтгэх 45, үйлчлэх 23 ажилчинтай үйл ажиллагааг явуулсан.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Му-ын ЗГ-ын 91-р тогтоол .БШУ-ны сайдын 170-р тушаал ,бусад боловсролын шинэчлэлтэй холбогдон гарсан хууль эрх зүйн актуудын мөрдлөг болгон ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НБББББ-ийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгах аар горим хэрэгжүүлсэн

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-аа БСШУС-ын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан баримт бичгийг мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,3 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	29,473.0	29,473.0
Авлага	32,888.8	714.2	32,174.6
Бараа материал	74,548.6	51,317.0	23,231.6

Үндсэн хөрөнгө	1,597,094.1	1,639,650.4	42,556.3
Нийт хөрөнгө	1,671,642.8	1,726,967.5	55,324.7
Өр төлбөр	0	2,214.3	-2,214.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	616,21.1	616,216.1	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,671,642.8	1,726,967.5	55,324.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 23,231.6 төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 42,556.3 мянган төгрөгөөр нэмэгджээ.

НББ-ийн бодлогын өөрчлөлтөөр 55.3 сая төгрөг нэмэгдсэн нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбогдон гарсан өөрчлөлт гэж тайлбарлаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,812,232.3 төгрөгөөр нийт зарлагыг 1,744,444.14 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,446,748.8 төгрөгийг улсын төсвөөс, авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс болон орон нутгийн төсөв мөн өөрийн орлого төслийн санхүүжилтээр нийт 1,812,232.3 төгрөгийн санхүүжилт авч 1,744,444.4 төгрөгийг зарцуулж үлдэгдэл 29,473.0 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	хөтөлбөр	зардал	Зардлын ангилал	Төсөв зарцуулах эрх	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн үлдэгдэл
			100041215160 Бу.Хишиг-Өндөр 11 жилийн сур-УТ			
1	80226	210901	Байр ашиглалтын үйлчилгээ	3,364.40	3,364.21	0.19
2	80312	210901	Сургалт семинар	1,682.20	1,682.00	0.20
3	81605	210901	Эрүүл мэндийн үзлэг	3,869.10	3,869.10	-
4	81801	210901	үдийн цай хөтөлбөр	67,816.90	66,625.02	1,191.88
5	81806	81806	Дотуур байрны үйлчилгээ	98,230.20	87,892.72	10,337.48
5	81806	210101	Үндсэн цалин	28,865.40	26,871.43	1,993.97
		210201	Нийгмийн даатгалын шимтгэл	2,453.60	2,278.98	174.62

		210202	Тэтгэмжийн даатгал	288.70	268.26	20.44
		210203	ҮОМШ-ний даатгал	230.90	214.61	16.29
		210204	Ажилгүйдлийн даатгал	57.70	53.65	4.05
		210205	Эрүүл мэндийн даатгал	577.30	536.53	40.77
		210502	Хоол, хүнс	63,131.60	55,044.61	8,086.99
		210901	Бараа үйлчилгээний бусад зарда	2,625.00	2,624.65	0.35
6	81816	210901	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	37,465.00	37,465.00	-
7	81823	210901	Боловсролын байгууллагын багш,	7,569.90	7,569.90	-
8	81834	210901	Боловсролын стандарт, сургалты	1,061,017.30	1,051,722.30	9,295.00
8	81834	210101	Үндсэн цалин	723,225.40	716,358.37	6,867.03
		210102	Нэмэгдэл	180,836.70	180,088.09	748.61
		210104	Урамшуулал	16,635.00	16,023.93	611.07
		210201	Нийгмийн даатгалын шимтгэл	78,259.30	77,792.03	467.27
		210202	Тэтгэмжийн даатгал	9,207.00	9,152.00	55.00
		210203	ҮОМШ-ний даатгал	7,365.60	7,320.75	44.85
		210204	Ажилгүйдлийн даатгал	1,841.40	1,788.15	53.25
		210205	Эрүүл мэндийн даатгал	18,413.90	17,966.15	447.75
		210806	Мэдээлэл технолгийн үйлчилгээ	8,411.00	8,411.00	-
		210901	Бараа үйлчилгээний бусад зарда	4,205.50	4,205.50	0.01
		210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	12,616.50	12,616.34	0.16
9	81835	210901	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	162,438.50	153,940.21	8,498.29
9	81835	210101	Үндсэн цалин	125,584.00	119,029.73	6,554.27
		210102	Нэмэгдэл	7,822.70	7,321.76	500.94
		210104	Урамшуулал	10,983.10	10,955.14	27.96
		210201	Нийгмийн даатгалын шимтгэл	12,273.10	11,483.16	789.95
		210202	Тэтгэмжийн даатгал	1,443.90	1,350.95	92.95
		210203	ҮОМШ-ний даатгал	1,155.10	1,080.74	74.36
		210204	Ажилгүйдлийн даатгал	288.80	247.16	41.64

		210205	Эрүүл мэндийн даатгал	2,887.80	2,471.58	416.22
10	81844	210901	Өөрийн орлого	1,260.00	1,410.00	(150.00)
			Гүйцэтгэл	1,260.00	1,259.99	0.01
11	81848	210901	Сурах бичгийн тїрээс	3,295.30	3,295.30	-
12	83601	210901	Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	4,550.00	4,550.00	-
			Нийт	1,452,708.80	1,423,235.75	29,473.05

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтээр 10,290.0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн. Энэ нь тогтвортой хөгжлийн боловсрол 2 удаа төсөл бичиж санхүүжилт авч төслийг хэрэгжүүлсэн.

1. Хөгжилтэй цаасхан төсөл бага ангийн багш нар 3,950.0 төгрөгийн төсөл бичиж төслийг амжилттай хэрэгжүүлж цаасыг дахин боловсруулан ашиглаж байгаа.

2. Амтыг алган дээрээс гэсэн 6,340.0 төгрөгийн төсөл бичиж хүлэмжийн аж ахуйг амжилттай хэрэгжүүлж сургуулийн гал тогоонд нийлүүлж ашиг шимийг хүртэж байгаа.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

1.Хөгжилтэй цаасхан төслийн хүрэх үр дүн бол хаягдал цаасыг ашиглан дахин боловсруулах

2.Амтыг алган дээрээс гэсэн төслийн хүрэх үр дүн газрыг ашиг шимийг хүртэж эко бүтээгдэхүүн жимс ногоог хүртэх юм.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 1,569.4 сая төгрөгөөс 75 хувиар буюу 20,387.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь Зарим сургалт семинарт цахимаар оролцож шатахуун болон томилолтын зардлыг хэмнэн ажилласан байна.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд нийт 253 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 253 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд илэрсэн зөрчил байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хишиг-Өндөр сумын ЕБС-ын 2022 оны 06 дүгээр сарын 23-ны өдрийн 1/46 тоот албан бичгээр албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	100
Албан шаардлага	1	11,123.0	1	11,123.0	0
Зөвлөмж	3	5,208.1	3	5,208.1	100
Нийт дүн	4	16,331.1	4	16,331,4	100

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйлгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 14.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 14,388,124.8 төгрөгийн ө баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

